

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2025 оны 1 сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Ард Санхүүгийн Нэгдэл ХК УБД: 9010001145 ҮЦК: AARD Утасны дугаар: +976 77003322	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүү, хөрөнгө оруулалт	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	28,614,263	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Санхүү хариуцсан захирал Г.Билгүүн Хянаж, баталсан: Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уянга	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Аудитлагдсан тайлан хавсаргасан.
	Орлогын тайлан	Аудитлагдсан тайлан хавсаргасан.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Аудитлагдсан тайлан хавсаргасан.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Аудитлагдсан тайлан хавсаргасан.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Аудитын компаниас зэрэг дүгнэлт өгсөн. Аудитын тайлан хавсаргасан.	
1.2	Аудитын тодорхойлох захидал	
	Аудитлагдсан тайлан хавсаргасан	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	

2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд	Нийт хөрөнгийн өгөөж (ТТМ) Өөрийн хөрөнгийн өгөөж (ТТМ) Цэвэр ашгийн маржин	0.81% 1.89% 24.88%
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа Эргэлтийн хөрөнгийн харьцаа Эргэлтийн хөрөнгө, нийт хөрөнгөд харьцах харьцаа	1.08 1.11 0.53
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулав.	
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй.	
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Аудитлагдсан тайлан хавсаргасан	
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		
	Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно. 2025 оны сүүлийн хагас жил - Сонирхлын зөрчилтэй хэлцэл: 1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нэгдэлийн оролцогч компанийн өмчлөлийн BS9 токеныг 1,273,114, 544 төгрөгөөр худалдаж авав. Огноо:2025.03.26 2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д 60,000,014 төгрөгийг 4 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2025.05.02 3. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн биет болон биет бус хөрөнгөөс 7 тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгийг Ард Кредит ХК-д худалдахыг зөвшөөрөв. Огноо: 2025.03.17 4. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эзэмшиж буй Ард Даатгал ХК-ийн 50 хувьтай тэнцэх хувьцааны нийт үнэлгээг 20,000,000,000 тэрбум байхаар тогтоож, холбогдох этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн худалдах хэлцэл хийхийг зөвшөөрөв. Огноо: 2025.03.17 5. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувь эзэмшил бүхий Өндөрхаан ХК-д 20,000,000,000 тэрбум төгрөгийн урт хугацаатай санхүүжилт олгохыг зөвшөөрөв. Огноо: 2025.03.17 6. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байгуулсан 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн ЗГ/MN730052111300148592 тоот зээлийн гэрээний хугацаа, хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулав. Огноо: 2025.06.26 7. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байгуулсан 2023 оны 8 сарын 30-ны өдрийн №1213000004606 тоот зээлийн гэрээний барьцаалах хөрөнгийн нэр тоо ширхэг, нэгж үнэд өөрчлөлт оруулав. Огноо: 2025.09.15 8. Ард Кредит ХК-ийн байгуулсан 2025 оны 2 сарын 27-ны өдрийн №950021002199000785 тоот зээлийн гэрээнд батлан даагчаар оролцов. Огноо: 2025.09.15 9. Ард Кредит Плас ХХК болон Ард Актив хооронд байгуулсан зээлийн гэрээнд батлан даагчаар оролцов. Огноо 2025.10.23		

4.	Цалин урамшууллын мэдээлэл <u>ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал (сая төгрөг):</u> Төсөв 2025: 396 Гүйцэтгэл 2025: 386 <u>Томилдолтын зардал</u> Төсөв 2025: 30 Гүйцэтгэл: 19 Гүйцэтгэл %(нийт): 95%
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл: Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь компанийн зохистой засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг нээлттэй ил тод явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын болон бусад оролцогч талуудын хоорондох харилцааг засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал: 2026 оны 4 сарын 30-ны өдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Тус хурлаар Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны Аудитлагдсан тайлангийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн төсвийг батлах болон Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Төлөөлөн Удирдах зөвлөл: 2025 онд нийт 4 удаагийн ээлжит хурал, 1 удаагийн ээлжит бус хурал, 9 удаагийн эцнээ санал хураалт явуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан тогтоол, шийдвэрүүдийг хууль журмын хүрээнд олон нийтэд мэдээллэж ажиллалаа. “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажуулалтад заасан үүрэг, даалгаврыг биелүүлэх, холбогдох материалыг хугацаанд нь илгээх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. <i>/Жилийн тайлан, ХЭХ-ын материалд хавсаргасан./</i>
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл: Зохицуулагч байгууллагаас зээл олголтод тавих өр-орлогын (DTI), барьцааны үнэлгээний (LTV) шаардлагыг чангатгаж, эх үүсвэрийн бүтэц, зохистой харьцаанд шинэчлэл хийж буй нь салбарын өсөлтийг хязгаарлах, эрсдэлийг бууруулах чиглэлд чиглэж байна. Үүний зэрэгцээ байгууллагуудаас капиталын хүрэлцээ, зээлийн чанар, эрсдэлийн удирдлагад илүү өндөр шаардлага тавигдаж байна. Улмаар санхүүжилтийн орон зай хумигдаж, нийт актив, зээлийн багц буурсан. Мөн банк бусын өр орлогын харьцаа чангарснаар давхар зээлтэй иргэдийн өрийг өрөөр дахин санхүүжүүлэх боломж буурснаас NPL өссөн байна. Даатгалын нягтрал буюу нэг хүнд ногдох хураамжийн орлого 2024 оноос 15.1% өсөж ₮163.2 мянгад хүрсэн нь салбарын цэвэр ашиг өсөхөд зэрэг нөлөө үзүүлэв. Түүнчлэн голлох бүтээгдэхүүнүүд болох хөрөнгийн даатгалын хураамж өмнөх оноос 25.1%, авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамж 23.8% өссөн байна. Гэсэн хэдий ч жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ашигт ажиллагааны маржин харьцангуй бага байгаа нь цаашид нийт ашигт ажиллагаанд дарамт учруулж болзошгүй юм. Ирэх онд багш, эмч нарын цалин нэмэгдэх нь инфляцын төсөөллийг өсгөх гол хүчин зүйл болж байна. Дотоод, гадаад орчны эрсдэлүүд инфляцыг нэмэгдүүлэх чиглэлд давамгайлж буй тул Мөнгөний бодлогын хороо бодлогын төлөвийг зөөлрүүлэх нөхцөл бүрдээгүй гэж үзэн бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр нь хүүний түвшнийг богино хугацаандаа өндөр түвшинд барих хандлагатай байна.

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ <table><tr><td>1</td><td>Ардын Тэтгэврийн Данс ХХК - 2,128,408</td><td>7.44%</td></tr><tr><td>2</td><td>Ард Бит ХХК - 1,910,699</td><td>6.68%</td></tr><tr><td>3</td><td>Бруно Рашле - 1,620,400</td><td>5.66%</td></tr><tr><td>4</td><td>А.Сүхдорж - 1,493,668</td><td>5.22%</td></tr><tr><td>5</td><td>Ард Лизинг ХХК - 1,369,937</td><td>4.79%</td></tr></table>	1	Ардын Тэтгэврийн Данс ХХК - 2,128,408	7.44%	2	Ард Бит ХХК - 1,910,699	6.68%	3	Бруно Рашле - 1,620,400	5.66%	4	А.Сүхдорж - 1,493,668	5.22%	5	Ард Лизинг ХХК - 1,369,937	4.79%
1	Ардын Тэтгэврийн Данс ХХК - 2,128,408	7.44%														
2	Ард Бит ХХК - 1,910,699	6.68%														
3	Бруно Рашле - 1,620,400	5.66%														
4	А.Сүхдорж - 1,493,668	5.22%														
5	Ард Лизинг ХХК - 1,369,937	4.79%														
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл Байхгүй.															
9.	Ногдол ашгийн мэдээлэл 2026 оны 2 сарын 19-ны өдрийн 26/03 тоот тогтоолоор 2025 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.															
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл Жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулав.															
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: Овог, нэр: Г.Билгүүн Албан тушаал: Санхүү хариуцсан захирал																
Гарын үсэг: 																